



УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ж.ЗОЛЖАРГАЛ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

Төрийн ордон, Жамъян Д.С. үхбаатарын талбай,
6 дугаар хороо 6 үхбаатар дүүрэг Улаанбаатар хот 4201
Утас: (011-51) 26 08 12 Факс: (011-51) 26 04 08
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2026.08.10 № ХЭГ/2694
танай _____-ны № _____-г

Асуулгын хариу хүргүүлэх тухай

Танаас 2026 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 43 дугаартай албан бичгээр ирүүлсэн "Нийслэлийн төсвийн зарцуулалт, хөрөнгө оруулалтын талаар" Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан асуулгын хариуг үүгээр хүргүүлж байна.

Хүлээн авч танилцана уу.

Хавсралт 12 хуудастай.



Монгол Улсын Засгийн газар
Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга
Баттөмөр Энхбаяр
2026.08.10 17:56



МОНГОЛ УЛС
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА

Наадамчдын зам 1200, Арцатын ам,
23 дугаар хороо, Хан-Уул дүүрэг,
Улаанбаатар хот, 17100
Утас: (976-11) 32 39 77, 32 71 99
Цахим хуудас: www.ulaanbaatar.mn

2026.07.31 № 01/4903

танай _____ -ны № _____ -т


Хариу хүргүүлэх тухай

Танаас ирүүлсэн "Мэдээлэл ирүүлэх тухай" 2026 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн ХЭГ/2370 дугаартай албан бичигтэй танилцлаа.

Тус албан бичигт дурдсан Монгол Улсын Их Хурлын нэр бүхий зарим гишүүдээс 2026 оны 06 дугаар сарын 15-16-ны өдөр зохион байгуулагдсан "Нийслэлийн 2024-2026 оны төсвийн зарцуулалт, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт холбогдох хууль, тогтоомжид нийцсэн байдал" сэдэвт ерөнхий сонсголын үеэр хэлэлцүүлсэн мэдээлэлтэй холбоотой асуулгын хариултыг бэлтгэн, хүргүүлж байна.


Хавсралт 1 хуудастай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ



Б.ПҮРЭВДАГВА

1726111716



УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ АСУУЛГЫН ХАРИУЛТ

№	УИХ-ийн гишүүдийн асуулга	НЗД-ын тайлбар
1	Нийслэлээс 16 мега төслийн нийт төсөвт өртөг 28.9 их наяд төгрөгт хүрч, 2026 оны төлөвлөгөөнд тулгуурлан тооцвол Нийслэлийн төсвийн алдагдал 2.4 их наяд төгрөг гарахаар байна. Энэ нөхцөлд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан төсвийн тусгай шаардлагауудыг биелүүлэх боломжтой эсэх, мөн нэгдсэн төсвийн тогтвортой байдлыг хангах талаар ямар арга хэмжээ авч байгаа талаар;	Нийслэлийн 2026 оны төсвийн орлого 5,502.8 тэрбум төгрөг, урьд оны үлдэгдэл 854.0 тэрбум төгрөг, үнэт цаасны үлдэгдэл 1301.1 тэрбум төгрөг, энэ онд арилжаалсан үнэт цаас 200.0 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг 7,857.9 тэрбум төгрөгийн зардалд зарцуулахаар төлөвлөгдсөн байна. Төсвийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.3-т "Орон нутгийн төсвийн урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэх зарлагыг төсөвт тусган баталж хэрэгжүүлэх ба зарлага нь санхүүжүүлэх эх үүсвэрээсээ хэтрэхгүй байна" гэж, Өрийн удирдлагын тухай хуулийн 28.1 хэсэгт "Аймаг, нийслэл нь тодорхой төсөл, арга хэмжээ, өмнө гаргасан үнэт цаасаа дахин санхүүжүүлэх зорилгоор үндэсний мөнгөн тэмдэгтээр дотоодын зах зээлд үнэт цаас гаргаж болно. Нийслэл нь гадаад үнэт цаасыг хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгасан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, өмнө гаргасан үнэт цаасаа дахин санхүүжүүлэх зориулалтаар Засгийн газрын өрийн баталгаатайгаар гаргаж болно" гэж тус тус заасан. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 4.1.1. "төсвийн тусгай шаардлага" гэж нэгдсэн төсвийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн, төсвийн богино, дунд, урт хугацааны бодлого, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг тодорхойлоход баримтлах, энэ хуулиар тогтоосон зохистой үзүүлэлтийн түвшин, харьцаа, хязгаарлалтыг, тус хуулийн 7 дугаар зүйлд төсвийн тусгай шаардлагыг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт төсвийн тэнцлийн зорилтыг тодорхойлж тусгах, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл боловсруулах, батлах, нэгдсэн төсвийн гүйцэтгэлийг гаргах, тайлагнах, батлахад баримтлахаар хуульчилсан бөгөөд 2026 оны нэгдсэн төсвийн суурь тэнцэл 2,070.9 тэрбум төгрөг /ДНБ-2 хувь/, тэнцвэржүүлсэн тэнцэл -1,050.0 /ДНБ-1 хувь/ байхаар Улсын Их хурал баталсан байна.

2	Төсвийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.3-т заасны дагуу орон нутгийн төсвийн урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэх зарлагыг төсөвт тусган баталж хэрэгжүүлдэг боловч энэ зарлага нь төсвийн орлогын хэсэгт тусгагддаггүй. Улмаар орон нутгийн төсөв алдагдалтай харагдах нөхцөл үүсэж, төсвийн төлөвлөлт ба гүйцэтгэл үнэн бодитойгоор тайлагнагдахгүй байгаа зөрчлийг залруулах талаар авч буй арга хэмжээ;	Төсвийн тухай хуулийн 7.1 хэсэгт зааснаар Төсвийн жил нь тухайн оны 1 дүгээр сарын 01-ний өдөр эхэлж, тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно, мөн хуулийн 4.1.9. "төсвийн орлого" гэж хууль тогтоомжийн дагуу улсын болон орон нутгийн төсөв бүрдүүлэх орлого, төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.1 хэсэгт нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурь" гэж мөнгө хүлээн авсан, эсхүл төлсөн эсэхээс хамаарахгүйгээр орлогыг олсон үед, зардлыг гарсан үед нь хүлээн зөвшөөрч бүртгэх аргыг ойлгоно гэж заасан. Иймээс өмнөх тайлант хугацаанд үүсэж бүртгэгдсэн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг дараагийн жилд дахин орлого болгон бүртгэхгүй болно. Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн аудитын тухай хууль, бусад холбогдох заавар, журмын хүрээнд нийслэлийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг үнэн бодитоор тайлагнаж аудитын байгуулагад хүргүүлдэг бөгөөд жил бүр Нийслэл дэх Төрийн аудитын газар аудит хийн, баталгаажуулдаг.
3	Нийслэлээс гаргаж байгаа үнэт цаасны хэмжээ, зориулалт, хүүгийн түвшин нэгдсэн төсөвт ямар ачаалал үзүүлэх, зээлийн эргэн төлөлтөд эрсдэл үүсэх эсэхийг Өрийн удирдлагын тухай хуулийн хүрээнд хэрхэн хянаж байгаа талаар;	Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4 дэх заалтад "Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлэгдсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүний 60 хувиас хэтрэхгүй байна" гэж заасан. Энэхүү заалтын хүрээнд Монгол Улсад үүсгэх нийт өрийг Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дүгнэлтэд үндэслэн Засгийн газрын хуралдаанаар шийдвэрлэдэг. Энэ хүрээнд орон нутаг үнэт цаас гаргах, өрийн баталгаа гаргах асуудлыг Засгийн газрын түвшинд шийдвэрлэдэг бөгөөд 2026 оноос эхлэн Засгийн газрын стратегийн баримт бичигт аймаг, нийслэлийн гаргасан үнэт цаасны орлогод эзлэх хязгаарыг баталж мөрдүүлэн ажиллаж байна. Нийслэлийн гаргасан үнэт цаас 2026 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын 13.4 хувийг, нийт зарлагын 11.8 хувийг тус тус эзэлж байна. Засгийн газрын өрийн удирдлагын стратегийн баримт бичигт нийслэлийн засаг даргын тамгын газрын үнэт цаасны нэрлэсэн үлдэгдлийн тухайн жилийн орлогод эзлэх дээд хязгаарыг 2025 онд 75.2 хувь, 2026 онд 70 хувиас хэтрэхгүй байхаар заасан. Тус үзүүлэлтээр тооцоход 2025 онд 64.3 хувь, 2026 онд 48.7 хувьтай буюу хязгаараас доогуур түвшинд байна.

4	Улсын болон нийслэлийн төсвөөр санхүүжүүлэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээний зааг, ялгаа, зохистой харилцааг Төсвийн тухай, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай болон холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд хэрхэн уялдуулах талаар баримталж буй бодлого;	Төсвийн тухай хууль, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулиар улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний чиг үүргийг тус тус зохицуулсан байдаг. Мөн Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд зааснаар Улсын төсвийн төслийг жил бүрийн намрын ээлжит чуулганаар хэлэлцэн 11 дүгээр сарын 15-ны дотор баталдаг бөгөөд улсын төсөвтэй уялдуулан аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь тухайн шатны жилийн төсвийн төслийг хэлэлцэн жил бүрийн 12 дугаар сарын 05-ны дотор баталдаг. Төсвийн төслийг боловсруулахдаа "Алсын хараа-2050", Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Орон нутгийн тухайн жилийн хөгжлийн төлөвлөгөө зэрэг улс, нийслэлийн дээрх бодлогын баримт бичгүүдийг үндэслэн дээрх хуулиар заасан чиг үүрэг болон цагалбарын дагуу улсын төсөвтэй уялдуулан боловруулж байна.
5	Орон нутагт төсвийн хөрөнгө оруулалтыг хуваарилах, томоохон төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ хүн ам, газар нутаг, эдийн засгийн онцлогийг харгалзан үзэхэд баримталсан бодлого, чиглэлийн талаар;	Төсвийн тухай хууль, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулиар орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний чиг үүргийг зохицуулсан байдаг. Мөн "Алсын хараа-2050", Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан орон нутаг мөн Нийслэлийг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Орон нутгийн тухайн жилийн хөгжлийн төлөвлөгөө зэрэг бодлогын баримт бичгүүдийг Эдийн засгийн хөгжлийн яаманд хянуулан баталдаг.

	Сангийн яам Орон нутгийн төсвийн төслийг хянаж, дээрх зохицуулалтын дагуу өөрийн чиг үүргийн хүрээнд төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг эдийн засаг, нийгмийн үр өгөөж, хөрөнгө оруулалтын үр ашиг, хэрэгжүүлэх бэлэн байдал, хөгжлийн бодлоготой нийцсэн байдал зэрэг шалгуурыг үндэслэн эрэмбэлж, үнэлэн төсвийн төсөлд тусгаж хуулийн цагалбарын дагуу батлан хэрэгжүүлж байна. Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэгт заасан зохицуулалтын хүрээнд нийслэлийн өмчит хуулийн этгээдээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээг тодорхойлохдоо нийтийн ашиг сонирхол, үйлчилгээний тасралтгүй байдал, аюулгүй ажиллагаа, төрийн болон нийтийн үйлчилгээний хүртээмж, мөн тухайн ажил, үйлчилгээг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх боломж бодитоор бүрдсэн эсэх нөхцөл байдлыг харгалзан үзэж ирсэн. Сүүлийн жилүүдэд нийслэлийн хэмжээнд хэрэгжиж буй мега төсөл, томоохон төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, хөрөнгө оруулалт, санхүүжилт, өмч хөрөнгийн ашиглалт, үр дүнд хяналт тавих, төслийн хэрэгжилтийн зохион байгуулалтыг хангах шаардлагатай холбоотойгоор 2024 оноос нийслэлийн өмчит болон өмчийн оролцоотой 13 аж ахуйн нэгж шинээр байгуулагдсан. Эдгээр аж ахуйн нэгж нь хувийн хэвшилтэй шууд өрсөлдөх зорилгоор бус, нийтийн ашиг сонирхол бүхий томоохон төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд нийслэлийн өмчийн хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэйгээр байгуулагдсан. Гэсэн хэдий ч хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх боломжтой, зах зээл дээр өрсөлдөөн бүрдсэн ажил, үйлчилгээг орон нутгийн өмчит хуулийн этгээдээр үргэлжлүүлэн гүйцэтгүүлэх нь шударга өрсөлдөөнд сөргөөр нөлөөлөх, зах зээлийн оролцогчдод тэгш бус нөхцөл үүсгэх эрсдэлтэй байж болзошгүй тул нийслэлийн зүгээс тухайн чиг үүрэг, үйл ажиллагааны давхардал, эдийн засгийн үр ашиг, зах зээлд үзүүлэх нөлөөллийг үе шаттайгаар үнэлж, оновчлох арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Тухайлбал, нийслэлийн өмчит хүүхдийн цэцэрлэгийн хүнс бэлтгэл, хүнс хангамжийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 4 байгууллагыг татан буулгаж, уг чиг үүргийг хувийн хэвшилд шилжүүлэх асуудлыг Нийслэлийн Засаг даргаас Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлээд байна.
6	Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэгт "...хувийн өмчийн хуулийн этгээдээр гүйцэтгүүлэх боломжгүй ажил үйлчилгээг..." орон нутгийн өмчит хуулийн этгээдээр гүйцэтгүүлэх тухай заалт хэрхэн хэрэгжиж байгаа, мөн сүүлийн жилүүдэд хувийн хэвшилийн гүйцэтгэх боломжтой болон гүйцэтгэж байгаа (барилгын, хүнс, хоол үйлдвэрлэл гэх мэт) салбаруудад нийслэлийн өмчит хуулийн этгээдийн тоо эрчимтэй өссөн нь өрсөлдөөнийг хязгаарлахаас гадна хувийн хэвшлийн хөгжилд давуу байдлаа ашиглан сөргөөр нөлөөлж байгаа эсэх талаар;

	Энэ нь хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэхээс гадна хүнс хангамжийн чиглэлийн ОНӨААТҮГ-ууд НӨАТ төлөгчөөр бүртгэгдсэнтэй холбоотойгоор гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний үнэд НӨАТ-ын 10 хувийн зардал нэмэгдэж, сургууль, цэцэрлэгт нийлүүлэх бүтээгдэхүүний нэгж өртөг өсөхөд нөлөөлж болзошгүй нөхцөлийг бууруулах ач холбогдолтой гэж үзэж байна. Иймд цаашид хууль тогтоомжид нийцүүлэн хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх боломжтой ажил, үйлчилгээ, чиг үүргийг үе шаттайгаар хувийн хэвшилд шилжүүлэх, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагааны давхардлыг бууруулах, зах зээлд өрсөлдөх шинжтэй үйл ажиллагааг хязгаарлах, шударга өрсөлдөөнийг хангах, төсөв, өмч хөрөнгийн үр ашигтай зарцуулалтыг нэмэгдүүлэх бодлогыг баримтлан ажиллаж байна.
Нийслэлийн төсвийн зарцуулалтад хяналт тавих үүрэгтэй иргэдийн Төлөөлөгчид төрийн захиргааны байгууллага, нийслэлийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлага, төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд ажиллаж, тухайн байгууллагын төсөв, төлөвлөгөө, тайланг хэлэлцэн батлахад биечлэн оролцож, захиран зарцуулж байгаа нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг	Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь тухайн нутаг дэвсгэрийн өөрөө удирдах байгууллага бөгөөд орон нутгийн хөгжлийн бодлого, төсөв, өмчийн удирдлага, хэрэгжилтэд хяналт тавих бүрэн эрхийг хэрэгжүүлдэг. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Компанийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөл, удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг томилж ажиллуулах эрхийг өмчлөгчийн төлөөллийн байгууллага хэрэгжүүлдэг. Энэ хүрээнд Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч нь тухайн хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлагын чиг үүргийг хэрэгжүүлэхгүй бөгөөд өмчлөгчийн эрх ашгийг төлөөлөх, бодлого, төлөвлөлт, тайлан, үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүргийн хүрээнд зөвлөлийн гишүүнээр ажилладаг. Төлөөлөн удирдах зөвлөл нь хамтын удирдлагын зарчмаар ажиллаж, асуудлыг олонхын саналаар шийдвэрлэдэг тул аливаа гишүүн дангаар төсөв, хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрийг захиран зарцуулах, гэрээ хэлцэл байгуулах, төлбөр тооцоо гүйцэтгэх, өдөр тутмын удирдлагын шийдвэр гаргах эрхгүй болно.

	сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.2, 11 дүгээр зүйлийн 11.1, 22 дугаар зүйлийн 22.3, 22.3.4, 23 дугаар зүйлийн 23.6, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.2 дахь заалт болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх;	Түүнчлэн Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу төлөөлөгч нь ашиг сонирхлын зөрчил үүсэж болзошгүй нөхцөл байдал бий болсон тохиолдолд энэ тухай мэдэгдэх, тухайн асуудлыг хэлэлцэх, санал хураах, шийдвэр гаргах ажиллагаанд оролцохоос татгалзах үүрэгтэй бөгөөд хуульд заасан хориглолт, хязгаарлалтыг мөрдөн ажилладаг. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч нь зөвлөлийн гишүүний хувьд олж авсан мэдээлэл, баримт материалыг зөвхөн хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд ашиглах бөгөөд өөртөө болон бусдад давуу байдал бий болгох, хувийн ашиг сонирхолд ашиглахыг хориглодог. Иймд Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн оролцоо нь өмчлөгчийн төлөөлөл болон хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх зорилготой бөгөөд тухайн хуулийн этгээдийн санхүү, төсөв, хөрөнгийг дангаар захиран зарцуулах, эсхүл гүйцэтгэх удирдлагын чиг үүргийг хэрэгжүүлэх эрх зүйн үндэслэлгүй болно. Цаашид холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, ашиг сонирхлын зөрчил болон чиг үүргийн давхардал үүсэх эрсдэлийг бууруулах зорилгоор төлөөлөгчдийн оролцож буй зөвлөл, хороодын бүрэлдэхүүн, чиг үүрэг, эрх хэмжээний зохицуулалтыг тогтмол нягтлан шалгаж, шаардлагатай тохиолдолд эрх бүхий байгууллагын зөвлөмж, дүгнэлтийн дагуу зохих арга хэмжээг авч ажиллана.
8	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчид цалин, урамшуулалгүй байгаа нь ашиг сонирхлоос ангид ажиллах нөхцөлийг эрсдэлд оруулж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль тогтоомжийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байгаа эсэх;	Урамшууллын хувьд Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2014 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 54 дүгээр тогтоолоор батлагдсан "Нийслэлийн өмчийн хуулийн этгээдийн удирдах зөвлөлийн ажиллах журам"-ын 6.1.2 дахь заалтад "Удирдах зөвлөлийн гишүүн нь сар бүр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй дүйцэхүйц хэмжээний цалин авах ба удирдах зөвлөл нь ажиллаж буй нийслэлийн өмчийн хуулийн этгээдээс цалингаас өөр урамшуулал, бэлэг, үйлчилгээ, мөнгөн орлого, зээл, тусламж авах, хөнгөлөлт эдлэхийг хориглоно" гэж заасан байна. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 174 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний цагийн цалин хөлсний хэмжээг тооцох оролцоонд суурилсан холимог аргачлал"-ын 2.1 дэх хэсэгт

		"Төрийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний сарын цалингийн хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг, эсхүл тухайн сарын болон салбар дундын хамтын хэлэлцээрээр тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр дахин нэмэгдүүлснээс ихгүй байна" гэж зохицуулсан байдаг. Мөн энэ тогтоолын 3 дахь заалтад "Төрийн өмчийн оролцоотой компани. орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой компанийн Төлөөлөн удирдах зөвлөл, Засаг дарга, Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд аргачлалыг мөрдөж ажиллахыг зөвлөсүгэй" гэж заасан.
9	"Мега" гэх төслүүдийг ямар шалгуураар, хэрхэн эрэмбэлж улсын ба орон нутгийн түвшинд ангилан хэрэгжүүлэх бодлого баримталж байгаа талаар;	"Алсын хараа-2050", Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг улсын бодлогын баримт бичгүүд, Нийслэлийг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Орон нутгийн тухайн жилийн хөгжлийн төлөвлөгөө зэрэг орон нутгийн бодлогын баримт бичгүүдэд нийгэм, эдийн засгийн хөгжлийг эрчимжүүлэх, иргэдийн амьдрах орчин, нөхцөл, амьдралын чанарыг сайжруулах зорилтуудыг тусган хэрэгжүүлж байна. Уг зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд тэргүүлэх ач холбогдол бүхий төсөл, хөтөлбөрүүдийг бодлогын баримт бичигт тусгасны дагуу үе шаттайгаар санхүүжүүлэн хэрэгжүүлж, нийгэм, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэхэд чиглэн ажиллаж байна.
10	Сангийн яамны дүгнэлт, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын мэдэгдэлд дурдсанаар хуулийн шаардлага хангаагүй төндөр шалгаруулалтын үйл ажиллагаанд тулгуурлан "Туулын хурдны зам" төслийн ажил гүйцэтгэчийг сонгон гэрээ байгуулж, нийслэлийн төсвөөс 500 тэрбум төгрөгийн урьдчилгаа төлбөр шилжүүлсэн нь улсын хөрөнгийг онц их хэмжээгээр үрэгдүүлсэн гэмт хэрэг мөн эсэх,	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар нь үнэлгээний хорооны зөвлөмж, дүгнэлтийг үндэслэн захиалагчийн хяналтын байгууллага болох Нийслэлийн Замын хөгжлийн газраас ирүүлсэн гэрээний төслийг иж бүрдлийн хувьд хянан, БНХАУ-ын "Хятадын хаюань групп" ХХК болон "Тяньжин өүбайвэй" ХХК-ийн түншлэлтэй 2025 оны 08 дугаар сарын 05-ны өдөр НХААГ/20250101139 дугаартай гэрээг баталгаажуулсан. Засгийн газрын 2025 оны 78 дугаар тогтоолын дагуу олон улсын зөвлөх инженерүүдийн холбоо /фидик/-ны гэрээний жишиг нөхцөлийг хэрэглэн гэрээ байгуулсан. Гэрээний хавсралт болох 2/А/ Гэрээний мэдээлэл хэсгийн 14.2-т гэрээний үнийн дүнгийн 21.32 хувь буюу 500.0 тэрбум төгрөгийн урьдчилгаа санхүүжилт олгохоор тусгагдсан бөгөөд Олон улсын зөвлөх инженерүүдийн холбоо /фидик/-ны гэрээний Улаан номны жишиг нөхцөлийн 14.2.1-т "Гүйцэтгэгч нь урьдчилгаа төлбөрийн дүнтэй тэнцэх мөнгөн дүнгээр болон валютаар Урьдчилгаа төлбөрийн баталгааг (өөрийн зардлаар) гаргуулах бөгөөд эх хувийг Захиалагчид, хуулбарыг нь

хэрэв тогтоогдсон бол хариуцлага тооцогдох албан тушаалтны талаарх мэдээлэл;	Инженерт тус тус хүргүүлэх үүргийг хүлээнэ. Энэхүү баталгааг тухайн улс орны (эсхүл өөр улсын) Захиалагчийн зөвшөөрсөн хуулийн этгээдээр гаргуулах бөгөөд тендерийн баримт бичгээр өгөгдсөн маягт эсхүл Захиалагчийн зөвшөөрсөн маягтыг ашиглана." гэж заасан. Дээрх гэрээний нөхцөл болон Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 43 дугаар зүйл, Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 278 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 4.8.12 "Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлээр олгох бөгөөд урьдчилгааг дараах тохиолдолд олгоно", 4.8.12.1 "тухайн төсөл, арга хэмжээнд урьдчилгаа олгох талаар худалдан авах ажиллагааны баримт бичиг болон гэрээнд тус тус тусгасан байх", 4.8.12.2 "урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргуулсан байх (Сангийн сайдын тушаалаар баталсан "Урьдчилгаа төлбөрийн баталгаа болон даатгалын маяг"-ын дагуу гаргана)" гэж заасны дагуу гүйцэтгэгчээс ирүүлсэн даатгалын урьдчилгаа төлбөрийн баталгааг үндэслэн ажлын бэлтгэл хангахад зориулан урьдчилгаа төлбөрийг олгосон. Тус асуудал нь хууль хяналтын байгууллагад шалгагдаж байна.
"Сэлбэ 20 минутын хот" төслийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газар 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 265 дугаар тогтоолоор шийдвэрлэсэн Засгийн газрын өрийн баталгаатай Нийслэлийн гадаад үнэт цаасны эргэн төлөгдөх хугацаа 2027 оны 10 дугаар сараас эхлэхэд ямар эх үүсвэрээс, хэрхэн барагдуулахаар төлөвлөж байгаа, энэ нь улсын нэгдсэн төсөвт ямар ачаалал үүсгэх талаар;	Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот нь 2024 онд Монгол Улсын Их хурлын 17 дугаар тогтоол, Засгийн газрын 265 дугаар тогтоолоор 500 сая ам.долларыг 2.8 жилийн хугацаатай 7.75 хувийн хүүтэй гаргасан. Тус үнэт цаасны эргэн төлөлтийг 6 сар тутам төлж байгаа бөгөөд өнөөдрийн байдлаар 173.5 тэрбум төгрөгийг нийслэлийн төсвөөс төлөөд байна. Үндсэн төлбөрийг хугацааны эцэст буюу 2027 оны 08 дугаар сарын 21-ны өдөр төлөх үүрэгтэй. Тус үнэт цаасыг Засгийн газрын өрийн баталгаатайгаар гаргасан ба эргэн төлөлтийг тухайн оны улс, нийслэлийн төсвийн орлогоос болон төслийн борлуулалтын орлогоос төлөхөөр төлөвлөж байна. Урьдчилсан байдлаар эргэн төлөлтөөс 100.0 сая ам.долларыг хугацаанд нь төлж 400.0 сая ам.долларыг Өрийн удирдлагын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28^{1.1} дэх хэсэгт "Аймаг, нийслэл нь тодорхой төсөл, арга хэмжээ, өмнө гаргасан үнэт цаасаа дахин санхүүжүүлэх зорилгоор үндэсний мөнгөн тэмдэгтээр дотоодын зах зээлд үнэт цаас гаргаж болно. Нийслэл нь гадаад үнэт цаасыг хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгасан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, өмнө гаргасан үнэт цаасаа дахин санхүүжүүлэх зориулалтаар Засгийн газрын өрийн баталгаатайгаар гаргаж болно." гэж заасны дагуу дахин санхүүжүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж байна.

12	"Сэлбэ 20 минутын хот" төслийн хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах үндсэн баримт бичиг болсон техник, эдийн засгийн үндэслэлд төлөвлөгдсөн 12,032 орон сууцны тоо явцын дунд 8,575 болон буурч, орон сууцны өртөг, борлуулах үнэ хувийн хэвшлийн төслүүдээс үнэтэй болж байгаа нь барилга, хот байгуулалт, орон сууцжуулалтын бодлоготой нийцэж байгаа эсэх;	Төслийн техник, эдийн засгийн үндэслэл дараагийн үе шатны баримт бичиг нь барилгажилтын төсөл бөгөөд тухайн баримт бичгийг холбогдох хуульд заасны дагуу Нийслэлийн Ерөнхий архитектороор батлуулсны үндсэн дээр дагаж мөрдөн ажиллана. Тухайн 12032 өрх нь ТЭЗҮ-ээр тодорхойлсон дүн бөгөөд дараагийн үе шатны баримт бичиг буюу нарийвчилсан зураг төсөл хийгдэх үед эхний барилгажилтын төслөөр 10006 өрх байхаар тооцон батлуулсан. ТЭЗҮ-ээр тодорхойлсон 12032 өрхөд нийцүүлэн төлөвлөлтөд өөрчлөлт оруулсан ч архитектур төлөвлөлтийн даалгаварт "тодорхойлсон хүн амын нягтралыг 300-460 хүн/га-аас хэтрүүлэхгүй төлөвлөнө" гэсэн шаардлагад нийцээгүй тул дахин өөрчлөлт оруулснаар нийт 10833 өрх буюу барилгажилтын төсөлд өөрчлөлт хийгдсэн. Тус 10833 өрхийн орон сууцнаас 8575 өрх нь нийслэлийн үнэт цаасны хөрөнгө болон "Сэлбэ хорин минутын хот корпорац" ХХК-ийн өөрийн орлогын хүрээнд, үлдсэн 2258 өрхийн 120 өрх нь Гэр Хорооллыг Хөгжүүлэх Хөрөнгө Оруулалтыг Дэмжих Хөтөлбөр төслийн хүрээнд хийгдсэн орон сууц юм. Хот байгуулалт, орон сууцжуулах бодлоготой нийцэж буй эсэх: Сэлбэ дэд төвд 50000 хүн оршин сууна гэж тооцсон ба дараагийн үе шатны баримт бичиг буюу хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд 23500 хүнээр тооцож инженерийн суурь дэд бүтэц хийгдсэн. Батлагдсан барилгажилтын төслийн төлөвлөлт, тооцоолол нь хот байгуулалтын бодлого, төлөвлөлтийн баримт бичигтэй уялдсан. Мөн Алсын хараа 2050, Улаанбаатар хотын 2040 оны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө зэрэг улс, нийслэлийн урт хугацааны бодлогын баримт бичигт гэр хорооллыг дахин төлөвлөн хөгжүүлэх, иргэдийн амьдрах орчин нөхцөлийг сайжруулан амьдрахад таатай орчин бүрдсэн хот болгон хөгжүүлэх зорилттой бүрэн нийцэж байгаа болно.
----	---	---

13	Хот байгуулалт, дэд бүтцийн төсөл хэрэгжүүлэх үйл явцад Захиргааны ерөнхий хууль болон холбогдох хууль тогтоомжид заасан төлөвлөлтийн сонгол, хэлэлцүүлэг, олон нийтийн оролцоотой холбоотой зүйл, заалтуудыг хэрхэн хэрэгжүүлж байгаа талаар;	Хот байгуулалт, дэд бүтцийн төсөл хэрэгжүүлэх явцад Захиргааны ерөнхий хууль, Хот байгуулалтын тухай хууль, Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тухай хууль зэрэг хууль тогтоомжийн дагуу төлөвлөлтийн сонгол, хэлэлцүүлэг, олон нийтийн оролцоог хангах ажиллагааг зохион байгуулж байна. Жишээлбэл Сэлбэ орон сууцжуулах төслийг хэрэгжүүлэх хүрээнд төслийг эхлүүлэх талаар шийдвэр гаргахаас эхлээд төслийг хэрэгжүүлж дуусах хүртэлх хэрэгжүүлэлтийн бүхий л үйл явцад олон нийтийн зөвлөлдөх уулзалтуудад тэдгээрийн ахлагчид болон нөлөөлөлд өртсөн айл өрхийн төлөөлөл, ашиг хүртэгсдийг урин оролцуулах, тэдний санаа бодол, хүсэл сонирхлыг сонсох шаардлагатай байдаг учраас хороодын дарга нар, хэсгийн ахлагч мөн оршин суугч иргэдэд чиглэсэн уулзалт, нэгдсэн сургалт, урьдчилсан санал хураалтыг Нийслэлийн орон сууцны корпораци ХК нь Нийслэлийн Орон сууцны бодлогын газар, Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төслийн нэгж, Улаанбаатар хотын орлогод нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл салбарын төслийн нэгжтэй хамтран Сонгинохайрхан дүүргийн 7, 8, 9, 10, 28, 40, Чингэлтэй дүүргийн 14, 18 болон Сүхбаатар дүүргийн 14, 15 дугаар хороодод 2023 оны VIII XI саруудад тогтмол хийсэн.
14	Засгийн газрын 2021 оны 146 дугаар тогтоолоор Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулахад чиглэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх зорилгоор жил бүр нийслэлийн төсөвт 420,0 тэрбум төгрөг тусгаж байхаар шийдвэрлэсний хэрэгжилтийг хэрхэн үнэлж байгаа, уг санхүүжилтийн	Тус ажил нь нууцын зэрэглэлд хамаарах ажил бөгөөд Төрийн болон албаны нууцын тухай хуулийн дагуу холбогдох шаардлагыг хангуулан хүргүүлнэ.

	хүрээнд Нийслэл болон Зам, тээврийн яам хамтран хэрэгжүүлсэн Замын хөдөлгөөний төлөвлөлт, зохицуулалтын нэгдсэн систем (RFID)-ийн төслийн 22,3 тэрбум төгрөгийн санхүүжилтийн зарцуулалт, хүрсэн үр дүн, төсөл зогссон шалтгаан, цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлэх эсэх талаар.	
--	--	--